

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1	1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудасны “Яамны тухай” цэсэнд яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг оруулсан бөгөөд тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн талаарх мэдээллүүдийг “Бодлого чиглэл” цэс болон “Мэдээ, мэдээлэл” цэснүүдэд цаг тухай бүр оруулан, шинэчилж байна. -Тайлант хугацаанд тус яамны цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт 394 мэдээлэл байршуулсан бөгөөд эдгээр мэдээллийг нийт 606,895 иргэн үзсэн байна. https://mlsp.gov.mn/page/detail/1033	100
2	1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Яамны газар, нэгжийн удирдлага болон албан хаагчидтай холбоо барих мэдээлэл буюу газрын үндсэн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаал, өрөөний утасны дугаар, цахим шуудан талаарх хүснэгтийг боловсруулж, яамны цахим хуудасны https://mlsp.gov.mn/page/detail/1049 хаяг дээр байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудасны Холбоо барих цэсэнд яамны албан ёсны хаяг, цахим шуудангийн хаяг, харуулын утас, бичиг хэргийн утас, хэвлэлийн төлөөлөгчийн утас, яамны факс, яамны цахим хуудас, ажиллах цагийн хуваарь зэрэг мэдээллүүдийг оруулж, өөрчлөлт гарвал тухай бүр шинэчилж байна.	100
3	1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	-Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг яамны сайтад байршуулан ажиллаж байна. https://mlsp.gov.mn/content/detail/2610 -Салбарын хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” -ын 2.7-д заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт шалгалтын чиглэлд хамаарах объектуудад эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа. Үнэлгээний үр дүнд шилэн хяналтын цахим	100

		<p>системийн мэдээллийн санд 14104 объектын эрсдэлийн үнэлгээ 2024 онд бүртгэгдсэнээс 4062 объект их эрсдэлтэй, 10042 объект дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.</p> <p>2025 онд хяналт шалгалтад хамрагдах объектийн жагсаалтыг Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлж, тус хорооны 2024.11.29-ний өдрийн 01 тоот тогтоолоор 2025 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө батлагдлаа.</p>	
4	1.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	<p>Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр хийсэн 4 төлөвлөгөөт хяналт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийлээ.</p> <p>2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад нийт 1050 объект хамрагдсан ба нийт 9081 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 5934 заалттай 545 албан шаардлага, 1,198,678.72 /нэг тэрбум нэг зуун ерэн найман сая зургаан зуун далан найман мянга далан хоёр/ төгрөгийн нөхөн төлбөрийн 59 акт, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу нийт 162 хуулийн этгээдэд 306,750.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулсан байна.</p> <p>Хяналт шалгалтад хамрагдсан объектуудад хяналтын хуудсаар үнэлгээ хийхэд:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль сахин мөрдөлтийн түвшин 65.6 хувь, • Эрсдэл үүсэх магадлал 34.4 хувь байна. <p>Объектуудын эрсдэл үүсэх магадлалын хувь 0.5 пунктээр буурсан, салбарын хууль сахин мөрдөлтийн түвшин 0,8 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй байна.</p> <p>Хяналт шалгалтын танилцуулгын дүнд үндэслэн АҮЭБЯ, ХББОСЯ, ЗТХЯ, СЯ, ГЕГ -т тухайн салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах, салбарын үйл ажиллагааг зохицуулж буй шаардлагатай дүрэм журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх талаарх арга хэмжээний саналыг хүргүүлээ.</p>	100
5	1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ГБХНХ-ын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т тайлагнан ажиллаж байна. ХШҮ-ны тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан болон яамны сайтад байршуулсан. https://mlsp.gov.mn/content?c=87, https://new.unelgee.gov.mn/home/</p>	100

<p>1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;</p>	<p>6</p>	<p>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл хариуцах албан тушаалтныг томилох тухай” А/243 дугаар тушаалыг баталсан. Тушаалыг 2024 оны 12 сарын 10-ны А/175 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд газар, хэлтсийн хариуцсан мэргэжилтнүүд яамны цахим хуудаст сар бүр чиг үүргийн дагуу холбогдох мэдээллээ боловсруулан байршуулж байна. Үүнд:</p> <p>-Яамны цахим хуудсанд “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээр”-г байршуулав.</p> <p>-Яамны цахим хуудсанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 03 дугаар тогтоол.</p> <p>https://mlsp.gov.mn/uploads/files/undesni_khoroo_tsalin_dood_khemjee_20231013_12.pdf</p> <p>-Нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон статистик мэдээллийг ГБХНХЯ-ны www.mlsp.gov.mn хуудас болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn цахим хуудаст тухай бүр байршуулж ажил олгогч, иргэд, олон нийтэд хүргэдэг.</p> <p>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон үүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/137 дугаар тушаалаар батлуулж яамны вэб хуудсанд байршуулсан.</p> <p>- Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан ХНХЯ-ны цахим хуудаст Хөдөлмөрийн тухай хууль гэсэн линк үүсгэн Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж гарсан 18 дүрэм, журам, аргачлалыг байршуулсан. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон өмнөх 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл заалтуудын харьцуулалт, Хөдөлмөрийн тухай хуулинд орсон өөрчлөлт, шинэчлэлтээр Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, хөдөлмөрийн гэрээний талуудын хариуцлага, Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулалт, Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны нийтлэг зохицуулалт, Хөдөлмөрийн гэрээний төрөл, түүний нэмэлт нөхцөл, Хөдөлмөрийн удирдлага, хөдөлмөрийн хяналт, Ажил, амралтын цаг, цалин хөлс, олговор зэрэг 13 сэдвээр PPT мэдээлэл болон видео хичээл бэлтгэн байршуулсан.</p>	<p>100</p>
---	----------	--	------------

[/ https://mlsp.gov.mn/content/detail/1897](https://mlsp.gov.mn/content/detail/1897).

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудасны “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын захиргааны хэм хэмжээний акт цэс”-нд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаал, “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/804, А/216 дугаар хамтарсан тушаал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус байршуулсан.

-ГБХНХЯ-ны www.mlsp.gov.mn хуудасны “Нийтлэг стандартууд цэс”-нд Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага. MNS 6949, Хохирогч түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633, Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага MNS 6751 стандартуудыг байршуулсан.
<https://mlsp.gov.mn/content/detail/1764>

-ГБХНХЯ-ны цахим хуудасны Ил тод хэсэгт ТБОНӨБҮХАТ хуулийн дагуу зөвлөх үйлчилгээ, бараа, үйлчилгээ худалдан авах зарыг байршуулж, сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй явуулж байна. <https://mlsp.gov.mn/content/detail/1083> Түүнчлэн шинээр гарсан бодлого, дүрэм, журам, стандарт болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр салбарын бодлогын баримт бичиг болон олон улсын гэрээ, конвенцыг байршуулаад байна.
<https://mlsp.gov.mn/content?c=34>

-Монгол Улсын Засгийн газрын бодлого, ГБХНХЯ-наас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд сурталчлан таниулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд байгууллагын вэб сайт mlsp.gov.mn болон сошиал платформ /фэйсбүүк, твиттер, инстаграм, юутуб/ ашиглан мэдээ мэдээллийг тогтмол олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Иргэдэд энгийн ойлгомжтой хүртээмжтэйгээр мэдээллийг хүргэх үүднээс сошиал платформын онцлогт тохирсон зурган болон видео контентуудыг бэлтгэн байршуулдаг. Өдөрт дунджаар сошиал платформд 10 орчим пост /мэдээ, постер, шторк, видео контент г.м/ байршуулдаг бол вэб сайтад 2-5 мэдээ байршуулдаг болно.

		<p>Вэб сайтын мэдээ мэдээлэл цэсэд цаг үе, үйл явдлын 288 мэдээг тухай бүр байршуулав. Төрийн нэгдсэн цахим хуудас www.gov.mn –д 2024 оны үйл явдлыг мэдээ мэдээллийг бүрэн байршуулав.</p> <p>Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай” тогтоол, Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор баиалсан “Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах тухай” тогтоол, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-г яамны сайтад байршуулсан.</p>	
7	1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	<p>Засгийн газрын 2024 оны 06, 37 дугаар тогтоолоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн тогтоолоор албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл авсан. Үүний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар төрийн захиргааны 124 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан бүтэц, зохион байгуулалттай холбогдуулан 55 албан тушаалд сонгон шалгаруулалт зарлуулахаар яамны цахим хуудас /mlsp.gov.mn/-д шилжин, сэлгэн ажиллах зарыг албан тушаалын тодорхойлолтын хамт байршуулсан. Мөн шинэчлэн баталсан албан тушаалын жагсаалтын дагуу албан хаагчдыг байршуулж, яамны цахим хуудсанд харьяалах нэгж, албан тушаалын нэр, эцэг эх, өөрийн нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаягыг шинэчлэн байршуулсан. Мөн хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд өөрчлөлт орох үед тухай бүр өөрчлөлт оруулан ажиллаж байна.</p>	100
8	1.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<p>-Тус яаманд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1494 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл ирүүлсэнээс 842 бичгээр, цахимаар, иргэд олон нийттэй харилцах төвөөс 741, биечлэн болон утсаар 11 ирсэн байна. Үүнээс 1440 өргөдөл шийдвэрлэж, 54 өргөдөл шийдвэрлэх шатандаа, хугацаа болоогүй байна. Шийдвэрлэлт 96,4 хувьтай байна.</p> <p>Үүнээс:</p>	70

		Салбарын хяналтын газар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 159 албан бичиг, 111 өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариутай 125 албан бичиг, 108 өргөдөл гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн, аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийн дагуу 12 төлөвлөгөөт бус шалгалт хийлээ. Төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээг тооцон ажиллав. https://mlsp.gov.mn/content/detail/3579	
9	1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Яамны цахим хуудсын статистик болон ил тод цэсэнд нийгмийн даатгалын үйлчилгээ болон нийгмийн халамжийн зарим үйлчилгээнд хамрагдагсдын мэдээллийг 2024 онд, мөн хөдөлмөрийн зах зээлийн сарын мэдээллийг Бодлого, чиглэл цэсний Хөдөлмөр эрхлэлт дэд цэсний Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээлэл хэсэгт сар бүр байршуулж байна. https://mlsp.gov.mn/report/31	100
10	1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр;	Нийт албан хаагчдад ажлын байран дахь эерэг зөв хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, хүмүүс хоорондын харилцааг дэмжих, харилцан ойлголцох нөхцөл байдлыг бүрдүүлэх, хамтын ажиллагааны дэвшилттэй арга барил, арга хэрэгсэл бий болгох, хүмүүс хоорондын харилцааг идэвхжүүлэх уур амьсгалыг эрүүлжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөөний дагуу сургалтуудыг Мэдээллийн цагаар сар бүр зохион байгуулан ажиллалаа. Тухайлбал, Яамны нийт албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах “ABLE систем”-ийн талаархи мэдээлэл, “Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ”, “Хөдөлмөр эрхлэлтийн E-job платформ”, “Архив, албан хэрэг хөтлөлт”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, журам”, “Ажлын байран дахь стресс менежмент” болон “Эрүүл зөв хооллолт”-ын чиглэлээр яамны аппаратын нийт албан хаагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн байна.	100
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
11	2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх, төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5 хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээллэн ажиллаж байгаа бөгөөд журам батлагдснаас хойш нийт 240 сул орон тооны мэдээллийг салбарын хэмжээнд нийтэд мэдээлж ажилласан байна. https://mlsp.gov.mn/content?c=61	100
12	2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс яам, агентлаг, харьяа байгууллагын удирдах 38, гүйцэтгэх 202 нийт 240 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Тусгай шалгалтыг Төрийн албаны	100

		зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулав. “Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг яамны цахим хуудаст байршуулсан. https://mlsp.gov.mn/content/detail/3583	
13	2.3. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г тус яамны дотоод сүлжээнд байршуулж, албан хаагчдад танилцуулсан. ГБХНХС-ын “Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм”-г яамны цахим хуудаст байршуулсан. https://mlsp.gov.mn/content?c=63	100
14	2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д заасны дагуу Яамны хүний нөөцийн бодлогын баримт бичиг, үнэлэх журмын төслийг боловсруулж байна.	70
15	2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Яамны хүний нөөцийг Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага, 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлага болон Төрийн албаны зөвлөлийн 2019 оны Төрийн жинхэнэ албаны удирдах гүйцэтгэх албан тушаалд тавигдах, мэргэжил, мэргэшил, боловсрол, туршлага, ур чадварын шаардлагыг хамгийн сайн хангаж байгаа иргэнийг нээлттэй Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулж томилох, хууль зөрчихгүй байх, иргэдийг төрийн албанд орж ажиллах тэгш боломжоор хандах, албан хаагчдын мэргэшсэн байх, тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангах, албан хаагчдын ажил, ар гэрийн тэнцвэрийг хангах, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, давхардал хийдлийг багасгах, албан хаагчдын мэдлэг ур чадвар, мэргэжлийн түвшин, гүйцэтгэлийн үр дүнд албан тушаал дэвшүүлэх, зэрэг дэв ахиулах, сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зэрэг хүний нөөцийн бодлогыг иргэд болон албан хаагчдад нээлттэй байлгаж, тэгш боломжоор хандахыг зорин ажилладаг.	100
16	2.6. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хагас, бүтэн жилээр биелэлтийг гаргуулан үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Тус журмыг яамны цахим хуудаст байршуулав. https://mlsp.gov.mn/content/detail/1259	100
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			

17	3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулж танилцуулга, холбогдох тооцооллын хамт 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/28 дугаар албан бичгээр УИХ, Сангийн Яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн бөгөөд PDF форматаар шилэн дансанд 2024.09.15-ны өдөр байршуулж нийтэд мэдээлсэн.	100
18	3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг shilendans.gov.mn сайтад мэдээлсэн.	100
19	3.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд Үндэсний Аудитын газраас аудит хийсэн аудитын тайланг shilendans.gov.mn сайтад мэдээлсэн	100
20	3.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн орлогод Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь 850,000,000 /Найман зуун тавин сая/ төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан. Энэ онд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, үйлчилгээ үзүүлэх, бүртгэл, хасалт, сунгалтын үйлчилгээний хураамжийн орлогод 2,778,055,899 /Хоёр тэр бум долоон зуун далан найман сая тавин таван мянга найман зуун ерэн ес/ төгрөг төвлөрснөөс 2,375,000.000 /хоёр тэр бум гурван зуун далан таван сая/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 403,055,899 /дөрвөн зуун гурван сая тавин таван мянга найман зуун ерэн ес/ төгрөгийг жилийн эцэст үлдэгдэлээр сангийн яаманд татуулсан.	100
21	3.5. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны сайтад хуулийн хугацаанд байршуулан олон нийтэд тайлагнаж ил тод болгосон.	100
22	3.6. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын 33,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага бүрээр тухай бүр shilendans.gov.mn сайтад мэдээлэн ажиллаж байна.	100
23	3.7. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	2024 оны жилийн эцсийн байдлаар цалингийн зардалаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш 264 удаагийн 43,625.9 сая төгрөгийн дүнтэй зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр нь гүйлгээний утга агуулга хүлээн авагчын нэр гэрээ тушаал шийдвэрийн хамт shilendans.gov.mn сайтад мэдээлэн ажиллаж байна.	100

24	3.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гараагүй.	100
25	3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	<p>Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай” А/53 дугаар тушаал гаргаж харьяа нэгжүүдэд хүргүүлж, улирал тутам тайланг авч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/119 дүгээр тушаалаар Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан бүх бүх шатны төсвийн захирагч нар хүргүүлж, санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, дотоод хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр холбогдох газар, хэлтсийн сар, улирал, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж, улирал тутам тайлагнаж ажиллахыг холбогдох газрын дарга нар, төсвийн захирагч нарт үүрэг болон хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай” А/53 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны 8 дугаар сарын 29, 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд ГБХНХЯ-болон харьяа ХБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ, БНСУ дахь ХНХ-ын үйлчилгээний төв, НДЕГ, ХХҮЕГ, ХГБХХЕГ газар болон харьяа НДГ, ХХҮГ, ХХҮХ, ХГБХГ зэрэг нийт 117 байгууллагын 2024 оны 7-8 дугаар сарын байдлаарх 215 шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн системд мэдээлэл байршуулсан байдал, тайлагналтад дотоод аудит хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулх, цаашид алдаа дутагдал давтан гаргасан, заасан хугацаанд зөрчлөө арилгах арга хэмжээ аваагүй албан тушаалтнуудад Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тухай бүр арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 12/796 дугаар албан бичгийг төсвийн захирагч нарт хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 11 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ.</p>	100

26	<p>3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;</p>	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хүрээнд 2024 оны хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөг шилэн данс болон www.tender.gov.mn сайтад байршуулан ажиллалаа.</p> <p>2024 онд хүүхэд, гэр бүлийн чиглэлээр шинээр хэрэгжүүлэх 18 төсөл арга хэмжээ, шилжих 13 төсөл арга хэмжээ, их засварт 2 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж 11 батлагдсан байна. Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан ба тендерийн үр дүнг цахим систем www.tender.gov.mn сайтад байршуулан мэдээлсэн.</p> <p>Худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээний тухай мэдээллийг цаг тухайд www.tender.gov.mn цахим системд мэдээлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.</p>	100
27	<p>3.11. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52.1.5 дахь хэсгийг үндэслэн Үндэсний аудитын газраас 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/45 тоот тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжин хэрэгжиж буй Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслан /Налайх дүүрэг/, Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ Хүүхэд, хамгаалал хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ Хүүхэд залуучууд ахмадын хөгжлийн барилга/Улаанбаатар, Хан-уул, 12-р хороо, Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл арга хэмжээнд аудит хийж, тайланг ирүүлсэн. Аудитаар нийт төсвийн ерөнхийлөн захирагч нарт 7 зүйл заалт бүхий дүгнэлт, 11 зөвлөмжийг ирүүлсэн байна. / худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 оны худалдан авалтын төлөвлөгөөг ил тод байдлаар 44 байгууллага нийтэлсэн байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу ТЕЗ-ын худалдан авалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд байршуулсан байна.</p> <p>Мөн 2023 оны аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/729 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж ажилласан.</p> <p>Цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах, үнэлгээний хорооны шийдвэрийг хуульд нийцсэн эсэхэд байнгын хяналт тавин, гэрээний хэрэгжилтэд анхааран ажиллана.</p>	100
28	<p>3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;</p>	<p>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 2024 оны худалдах авах ажиллагааны тайланг цахим систем www.tender.gov.mn сайтад байршуулж, баталгаажуулж ажиллах тухай чиглэлийг харьяа агентлаг, байгууллагуудад хүргүүлэн ажилласан.</p>	100

29	3.13. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	<p>Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар ГБХНХСайдын багцад нийт 48,7 тэрбум батлагдсан бөгөөд жилийн байдлаар холбогдох хууль журмын дагуу ТАХ-ний гүйцэтгэлд 33,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем болох rimis цахим системээр төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй 3 төслүүдийн хүрээнд 2024 ж мөн цахим систем болох odamis системээр холбогдох хууль журмын дагуу хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтыг хэрэгжүүлж ажилласан.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар тус цахим системээр дамжуулан нийт 46,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.</p>	100
30	3.14. Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд 2035 он хүртэл шаардагдах эрэлттэй ажил, мэргэжлийн судалгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөдөлмөрийн чиглэлээр мэргэшсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэгч Эм Эм Си Жи ХХК хамтран “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” судалгааг гүйцэтгэж, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулсан. https://www.institute.gov.mn/storage/sudalgaas/June2024/K2Hht11WmRD6jwMac4vA.pdf - ХХҮЕГ-ын “Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа”-ны мэдээлэлд тулгуурлан эмзэг бүлгийн өрхийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн идэвх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн талаарх асуудлуудыг тодруулан “Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт 2024” судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгаан институтээс гүйцэтгэж, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулсан https://www.institute.gov.mn/storage/sudalgaas/June2024/qmLleyAxfx6zLwLgdHd.pdf - Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилго бүхий "Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал 2024" судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 21 аймаг, 9 дүүргээс нэгтгэн авч, дата хяналт, кодлолын ажлыг эхлүүлээд байна. Энэхүү судалгааг олон улсын аргачлалаар 2010 оноос эхлэн жил бүр гүйцэтгэж ирсэн бөгөөд судалгааны үр дүнг 2024 оны 12 сард танилцуулна. <p>Ажиллагчдын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, зэргийг нарийвчлан тодорхойлох, өмнөх жилүүдийн мэдээллийг шинэчлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох зорилгоор 2019, 2021, 2023 онуудад “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-г гүйцэтгэсэн. Энэ онд хийгдэх "Цалин хөлсийн бүтцийн судалгаанд хийсэн шинжилгээний ажил" судалгааны тайланг бэлэн болгох ажил үргэлжилж байна. Судалгааны үр дүнг 2025 оны 01 сард танилцуулна.</p>	100

31	3.15. Хууль тогтоомжид заасан бусад.	-	ҮБ
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
32	4.1. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	<p>1/ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу материал хүлээн авч, шийдвэрлэж байна. Үйлчилгээг үзүүлэхэд тус яамнаас аливаа үйлчилгээний хураамж хуулийн этгээдээс авдаггүй болно. Улсын тэмдэгтийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэж буй хуулийн этгээд тусгай зөвшөөрөл шинээр авахад 3 сая төгрөг, сунгуулахад 1 сая төгрөгийг тус тус дүүргийн татварын хэлтэст тушаадаг.</p> <p>2/Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу үнэ төлбөргүй үзүүлж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох журмыг шинэчлэн баталсан. Хөдөлмөрийн хувийн биржээр бүртгүүлэх хуулийн этгээд нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгэх эрх бүхий байгууллагад хандана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2.1.Хөдөлмөрийн хувийн биржээр бүртгүүлэх хуулийн этгээд нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгэх эрх бүхий байгууллагад хандана. - 2.1.1. албан хүсэлт; - 2.1.2. хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа; /хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тусгагдсан байх/ - 2.1.3. удирдах ажилтан/захирал/-ны анкет; - 2.1.4. хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа явуулах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүйг нотлох лавлагаа; - 2.1.5. хөдөлмөрийн хувийн биржийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх журам, ёс зүйн дүрэм, бизнес төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга; - 2.1.6. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх, мэргэшсэн зөвлөх, ажил зуучлал хариуцсан ажилтны анкет, диплом, гэрчилгээний хуулбар, тухайн байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа; - 2.1.7. "MNS6620:2016" стандартын шаардлага хангасан эсэх талаарх аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлт. <p>Холбогдох мэдээллийг https://mlsp.gov.mn/content/detail/2626 цахим хаягт оруулсан байна.</p>	100
33	4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон,	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.	100

	сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Хууль хэрэгжиж эхэлсэнээс нийт 72 байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон байна. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын мэдээллийг тухай бүр яамны цахим хаяг https://mlsp.gov.mn/content/detail/2626 болон тусгай зөвшөөрлийн нэгдсэн сан болох "lisence.mn" сайтад https://license.mn/licensed-organizations/tabs байршуулсан болно.	
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
34	5.1. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	<p>1. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төслийг дараах цахим хуудсанд байршуулж, ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Их хурлын 2024 оны 6 сарын 5-ны өдрийн чуулганаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр болсон. Иймд дээрх хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлах "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журам", "Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам", "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ын төслийг 2024.11.18-ны өдөр https://mlsp.gov.mn/content/detail/3528 цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтээс нээлттэй санал авсан ба 2 байгууллагаас албан бичгээр санал ирүүлсэн. • Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дээрх хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан Насны хишиг олгох журмыг шинэчлэх, Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журмыг шинэчлэх, мөн тогтоолын 2, 3 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах, "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулж, "Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг 2024.08.27-ны өдөр https://mlsp.gov.mn/content/detail/3414 цахим хуудсанд иргэд, олон нийтээс нээлттэй санал авахаар байршуулсан ба санал ирээгүй. • Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлах Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний журмын төслийг 2024.11.15-ны өдөр https://mlsp.gov.mn/content/detail/3549 цахим хуудсанд иргэд, олон нийтээс нээлттэй санал авахаар байршуулсан ба санал ирээгүй. 	100

		<ul style="list-style-type: none">• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, үзэл баримтлал, хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан https://mlsp.gov.mn/content/detail/3269 цахим хуудсанд байршуулж санал авсан. Мөн хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагын төлөөлөлд 12 удаа хэлэлцүүлсэн. Хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төсөлд шинээр 4 зүйл нэмэгдэж, 11 бүлэг 45 зүйлтэй болсон.• Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагын төсөлд https://mlsp.gov.mn/content/detail/3526 цахим хуудсанд байршуулж санал авсан. Нийт хандалт 307.• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулж болно.” мөн хуулийн 41.2-т Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэж тус тус заасан. Энэ хүрээнд “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд дараах үндэслэлийн дагуу хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг тусгаж, тогтоолын төслийг боловсруулан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-ын төсөлд https://mlsp.gov.mn/content/detail/3574 цахим хуудсанд байршуулж санал авч байна. Нийт хандалт 21.• Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын төсөл https://www.cfqa.gov.mn/website/news.aspx?id=4096 цахим хуудсанд байршуулж, санал авсан. Уг журмыг Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.• Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан /https://mlsp.gov.mn/content?c=5 цахим хуудсанд байршуулж, 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүртэл нээлттэй хэлэлцүүлж, санал авсан. Тус хугацаанд ямар нэгэн санал, шүүмж, өргөдөл, хүсэлт ирээгүй. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан.• Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, зааврын төслийг боловсруулан /https://mlsp.gov.mn/content?c=5/ цахим хуудсанд байршуулж, нээлттэй санал авсан.	
--	--	--	--

	<ul style="list-style-type: none">• “Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3391 цахим хуудсанд байршуулж, санал авсан. Журмын төсөл албажих шатанд байна.• Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий “Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3394 цахим хуудсанд санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах саналтайгаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.• “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3395 цахим хуудсанд санал авч, батлах саналтайгаар ХЗДХЯ, ЦХИХХЯ-нд хүргүүлсэн.• “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3392 цахим хуудсанд байршуулсан. 2024 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар санал, шүүмж, өргөдөл, хүсэлт ирээгүй.• “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3418 цахим хуудсанд байршуулж, Боловсролын яаманд хүргүүлсэн.• “Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3393 цахим хуудсанд байршуулж, Боловсролын яаманд хүргүүлсэн.• “Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3421 цахим хуудсанд байршуулж, Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Тус стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Техникийн хорооны хурлаар хэлэлцэн баталсан.• Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлагын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3420 цахим хуудсанд; Стандарт хэмжил зүйн газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Техникийн хорооны хурлаар хэлэлцэн баталсан.• Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, түүнийг үзүүлэх байгууллагад тавигдах нийтлэг шаардлага стандартын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3396 цахим хуудсанд байршуулж, Стандартчилал, хэмжил зүйн газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлсэн.	
--	--	--

		<ul style="list-style-type: none"> Жагсаал цуглааны үеийн хүүхэд хамгааллын нийтлэг шаардлагын төслийг https://mlsp.gov.mn/content/detail/3419 цахим хуудсанд байршуулж, санал аван Стандартчилал, хэмжил зүйн газарт батлах саналтай хүргэсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/32 дугаар тушаалыг үндэслэн Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн үндэсний хороо байгуулах зорилгоор Хорооны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах нээлттэй зарлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсанд https://mlsp.gov.mn/content/detail/3460/ 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байршуулсан. Иргэдээс санал авах хугацаа үргэлжилж байна. Одоогоор санал ирүүлээгүй. Хүүхдийн эрхийн тухай хуулийг даган гарах дараах актын төсөлд олон нийтийн санал авсан. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийн төсөлд https://mlsp.gov.mn/content/detail/3349 цахим хуудсаар санал авч, нийт хандалт 811 байна. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 142 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай ухулийн 12.1.3-т заасны дагуу журмын төслийг шинэчлэн боловсруулж, “ХОХИРОГЧИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛСАН ТУХАЙ цахим хуудсаар санал авч, ГБХНХ-ын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар батлагдан Захиргааны хэм, хэмжээний актад бүртгүүлсэн. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг - https://mlsp.gov.mn/content/detail/3493 цахим хуудсанд; Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох журмын төслийг - https://mlsp.gov.mn/content/detail/3458 цахим хуудсанд. 	
35	5.2. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Байхгүй	ҮБ
36	5.3. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Байхгүй	ҮБ
37	5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны конторын барилгын зориулалтаар 1053 кв газрыг Төрийн байгууллагын эзэмших гэрчилгээний дугаартай эзэмшиж байна.	100
38	5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн	100

	этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг мэдээлэл байхгүй болно.	
39	5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулалтад оролцсон мэдээлэл байхгүй болно.	100
40	5.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлаагүй, төсвийн хөрөнгийг ашиглалт болон ашиглалтаас гаргаагүй болно.	100
41	5.8. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл	Байхгүй	ҮБ

	мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;		
42	5.9. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/”, “Нөхөн сэргээх, хүүхэд хөгжил, сургалтын төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”, “Спорт заал бүхий “Иргэдийн хөгжлийн төв”-ийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9, 10, 16 дугаар хороо/” “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн цэцэрлэгийн дээврийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, “Олон улсын хүүхдийн найрамдал зуслангийн их засвар, шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ Багц 2 Дулааны цехийн өргөтгөл, их засварын ажил”, мөн АХБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ нийт 6 төсөл, арга хэмжээний Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажсан байна.	100
43	5.10. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Байхгүй	ҮБ
44	5.11. Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Тайлант хугацаанд нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал open.data.gov.mn-д Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа агентлаг, байгууллагын нийт 84 төрлийн нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй нээлттэй өгөгдлийг байршуулаад байна. (линкүүд https://opendata.gov.mn/data/9081739 , https://opendata.gov.mn/data/5209056 , https://opendata.gov.mn/data/6898351 , https://opendata.gov.mn/data/6345492 ,	100
45	5.12. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцаж буй төрийн албан хаагч байхгүй байна.	ҮБ

46	5.13. Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. Төлөвлөгөөний төслийг салбар дундын ажлын хэсгээр хэлэлцүүлж, Засгийн газрын тогтоолоор батлуулахаар ажиллаж байна.</p> <p>ЮНЕСКО байгууллагатай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр НҮБ-ын байранд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын тайлан боловсруулахад анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад УИХ-ын тамгын газар, бүх яам, 10 агентлаг, Хүний эрхийн үндэсний комисс, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо зэрэг 30 гаруй байгууллагын 60 гаран төлөөлөл оролцлоо. Сургалтын үеэр хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын агуулгыг танин мэдүүлэх, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийг салбар бүрээр нь ангилан агуулгыг нь тайлбарлан таниулах, бодлого боловсруулах, үйл ажиллагаа зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хүний эрхийн мэдрэмжтэйгээр зохион байгуулах аргачлалыг таниулах агуулгаар зохион байгууллаа.</p> <p>Мөн “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Монгол улсын засгийн газарт 2015, 2023 онуудад ирүүлсэн зөвлөмжийн гарын авлага”-ыг боловсруулж, хэвлүүлэн төрийн байгууллагынханд 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 03/656 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Конвенцын хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр О.Саранчулуун гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.</p>	100
Нийт дундаж үнэлгээний хувь		98.5	